

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLII

Улаанбаатар

2018

МОНГОЛЧУУДЫН ХЭМЖЭЭ БИЕНДЭЭ БАЙДАГ

А.Пүрэвжанцан


Түлхүүр үг: алд, дэлэм, гар, хуруу, тохой

Хүн төрөлхтөний түүхэн дэх мэдлэг ухааны нэг бол хэм хэмжээ, хэмжих ёс, хэмжээ илэрхийлэх арга мөн. Төв Азийн өндөрлөгт орших монголчуудын хувьд жилийн дөрвөн улиралтай, улирал бүр нь өөрийн аяг араншинтай, цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, Алтай, Хангай тал хээр, говь хосолсон өргөн уудам газар нутагтай, уламжлалт нүүдлийн сонгодог мал аж ахуйг эрхэлдэг, тэнгэр шүтлэг, бөө мөргөл, бурхны шашин шүтдэг зэргээс хамааран хэмжих уламжлал, хэмжээ илэрхийлэх арга, сэтгэхүй сэтгэлгээ нь нэн өвөрмөц хэв шинжийг хадгалсаар өнөөг хүрчээ.

Бид “Монгол хүний хэмжээс биендээ байдаг” гэж хэлэлцдэг. Үүнийг тодруулах үүднээс хүний биед байх хэмжээсүүдийг агуулга тодорхойлолт, дүйх утга, жишээ баримт, зураг хөргийн хамт авч үзье. Тухайлбал: *алга* (алга дарам, алгын чинээ), *алд* (үзүүр алд, мухар алд), *алхам* (бүтэн алхам, хагас алхам, 1 алхам, 2 алхам...), *атга* (атга дүүрэн, атгасан гар шиг), *балга* (балга цай, балга ус), *борви* (борвиор татах), *босоо хүний дайтай* (босоо хүний хэртэй), *бүсэлхийн зэрэг* (бүсэлхийгээр татах), *гиигэм* (цуваа, зэрэгцээ), *дэлэм* (мухар дэлэм, үзүүр дэлэм), *өгзөг* (өгзгөөр татах), *өмх* (өмх max), *сөөм* (мухар сөөм, үзүүр сөөм), *тохой* (мухар тохой, үзүүр тохой), *төө* (мухар төө, үзүүр төө), *суга* (сугаар татах), *хумс* (хар хумсны хэртэй, хумсын чинэхэн), *хуруу* (1, 2, 3, 4, 5 хуруу), *цээж* (цээжээр татах), *чигчий* (чигчийн чинээ), *чимх* (чимх давс), *шагай* (шагайн чинээ), *эрхий* (эрхий дарам, эрхийн чинээ) гэхчлэн нэрлэжээ.

Шинжлэх ухаан хэдийвээр эш баримт, гарцаагүй нотолгоо дүгнэлт шаардах ч дээрх хэмжээст хэллэгүүдийн тоон утга, дүйцэх оноолтыг тогтоох тийм хялбархан биш бололтой. Үүнийг үл өгүүлэн доорх цөөн жишээн дээр тулгуурлан зарим нэгэн тайлбарыг тоймлон өгүүльье.

1. АЛГА: Гарын таван хурууг дэлгэсэнтэй тэнцэх дайтай. (5 хуруу буюу 10 см орчим) Жишээ нь: “Данжила чи нүдээ хөдөлж байсан цагт харийн элэгтэнд **алга дарам** газар ч бүү өг” (Догмид, 2014:23)




2. АЛД: Хоёр гарын алгыг дэлгэж, сугаараа тэнийлгэсэнтэй тэнцэх дайтайг үзүүр алд, нэг гарын атган тэнийлгэвээс мухар алд хэмээнэ (Үзүүр алд 160-180 см, мухар алд 130- 140 см орчим). Жишээ нь: “Ахыгаа **алд** хүндэл”.

3. АЛХАМ: Хөлийн алхахад хорогдох хоёр хөлийн хоорондын зайд. Дүүрэн алхвал бүтэн алхам, дутуу алхвал хагас алхам гэж нэрийднэ. Мөн алхааны тоогоор 1, 2, 3... алхам ч гэдэг (Бүтэн алхам 90-100 см, хагас алхам 50-60 см). Жишээ нь: “Боорчи хормойгоо өндөр сөхөн их алхдаар Жононгийн барьсан цацарт орж ирвэй” (Шүүдэрцэцэг, 2004:131).



4. АТГА: Гарын алганд багтах хэмжээ (100-200 гр орчим). Жишээ нь: “Хааяхан эгч дээрээ хүрч очиход **атга дүүрэн** чихэр атгуулдагсан”.

5. БОРВИ: Хөлийн өсгийнөөс өвдөгний доохно хүртлэх зайд (40-50 см орчим). Жишээ нь: “Мэндээ эгч шүхрээ барьж, хормойгоо шуугаад нуурын захын лаг шаварт **борвиороо таттал** шигдсэн хөлөө дээр өргөн явна” (Догмид, 2018:6).



6. ДЭЛЭМ: Алгыг тэнийлгэн, хоёр гарын нэгийг тохойгоороо нугалан цээжин тус газар барьсан хэмжээ (Үзүүр дэлэм 90 см орчим). Гарын алгыг атгасан бол (Мухар дэлэм 80 см орчим). Жишээ нь: “Дүүгээ дэлэм хүндэл”.

7. СӨӨМ: Эрхий хурууны үзүүрээс долоовор хурууны үзүүрийг хүртэл тэнийлгэсэнтэй дүйх хэмжээ (Үзүүр сөөм 16-18 см орчим). Долоовор хурууны дунд үеэр нугаласнаас эрхий хурууны үзүүр хүртэл (Мухар сөөм 12-15 см орчим). Жишээ нь: “Үнэн юм **алд дэлэм, үгүй юм мухар сөөм**” (Пүрэв, 2011:38).



8. ТӨӨ: Эрхий хурууны үзүүрээс дунд хурууны үзүүрийг хүртэл тэнийлгэсэнтэй дүйнэ (Үзүүр төө 20-22 см орчим). Дунд хурууны дунд үеэр нугалснаас эрхий хурууны үзүүр хүртэл (Мухар төө 18-20 см орчим). Жишээ нь: “Төлөгний ноос **төө** зузаан”.

9. ХУМСЫН ЧИНЭЭ: Хүний гарын хумс 1см орчим хэмжээтэй дүйнэ. Жишээ нь: “Тэр дугуй боовыг би Жанцан гэдэг бэлтэй айлд сар шинээр гэрийн ерөөл тавьж олдог болсонд хүүхдүүд атаарахаа боловч тасгийн хүүхдийн тоогоор **хумсын чинээ** хэлтэлж өгөөд санааг амраана” (Доржготов, 2009:25]



Энэ бүхнээс дүгнэхэд монголчуудын биеийн хэмжээ илэрхийлэх эдгээр үгс үндэсний хэв шинжээ хадгалсан суурьшмал болон хагас суурьшмал соёл иргэншилтэй ард түмний хувьд нэн их онцлогтой байдаг. Бидний хэл, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх уламжлалт ахуй соёлтой холбоотой дээрх үг хэллэгийг судлах нь монгол хэлний үгийн сангийн бүрдэл, түүний хувьсал хөгжил хийгээд утга үүрэг, хэрэглээний өөрчлөлт байдал зэргийг тодруулахад чухал ач холбогдолтой болно.

Нөгөө талаар асар их хурдтай хөгжин буй даяаршлын өнөө үед олон төрлийн хэмжээ илэрхийлэх үг хэллэгийг хэрхэн харгуулах, оноо дүйлгэх, уламжлалт ёс, арга ухаантай холбон тайлбарлах эсэх нь бас ихээхэн анхаарал татдаг юм.

Summary

As a conclusion, the aforementioned words and expressions using any body of human for measuring are quite special for the sedentary and semi-sedentary people. Those are a kind of representatives of the language and thinking and are based on the traditional lifestyle and culture.

As a result, these words and expressions are, in this paper, studied and analysed for the formation particularly their development, meanings, functions and usages of the Mongolian language lexis.

Номзүй

Догмид Б. *Нутгийн чулуу нулжимстай*. Уб., 2007.

Догмид Б. *Хөөрхий*. Уб., 2008.

Доржготов Ц. *Үдийийн улгэр*. Уб., 2009.

Пүрэвжанцан А. *Арын номин хангайн хоймор сайхан нутаг*. Уб., 2016.

Цэвэл Я. *Монгол хэлний товч тайлбар толь*. Уб., 1963.

Шүүдэрцэцэг Б. *Сорхугтан*. Уб., 2004.